

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

08.10 - 08.14



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдсан бөгөөд, S&P500 индекс бүх цаг үеийн хамгийн өндөр цэгээсээ 0.2%-ийн мужид хүрсэн байна. FedEx болон United Parcel Service зэрэг ачаа хүргэлтийн компаниудын өсөлт S&P500 индексийн сагсанд багтах аж үйлдвэрлэлийн салбар өсөлттэй байхад нөлөөлсөн байна. Урт хугацаат ЗГҮЦ-ны өгөөжийн түвшин нэмэгдсэнээр хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгийн салбарыг сонирхох нь багассан байна.

Нэмэлт эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжих хүлээлттэй холбоотой зах зээл өсөлттэй байлаа. Өнгөрсөн долоо хоногийн амралтын өдрүүдээр ерөнхийлөгч Дональд Трамп нэмэлт ажилгүйдлийн тэтгэмж олгох, албадан гаргахыг хориглох, оюутны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах болон орлогын татварыг хөнгөлөх зэрэг үйл ажиллагааг зөвшөөрөн гарын үсэг зурсан байна. Хэдийгээр шүүмжлэгчид тус шийдвэрийг үндсэн хууль зөрчиж байгаа болон үр ашигтай байдалд нь эргэлзэж байгаа ч, хөрөнгө оруулагчдад энэхүү шийдвэр таалагдаж байгаа юм байна. Тэд мөн эрх баригчдыг нэмэлт 1.5 тэрбум долларын хөтөлбөрийн зөвшилцөлд хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд коронавирусийн вакцин, эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүд болон эдийн засгийн сэргэлт нэмэгдэх магадлалтай байгаатай холбоотойгоор энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Гэхдээ COVID-19 цар тахлын 2 дахь давлагаа Европт гарч болзошгүй байгаа учраас Их Британи улс аяллын хоригоо чангатгасан нь хөрөнгийн зах зээлийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ. STOXX Europe 600 индекс 1.24%-аар, DAX индекс 1.79%-аар, CAC 40 индекс 1.50%-аар, FTSE MIB индекс 2.62%-аар, FTSE 100 индекс 0.96%-аар тус тус өссөн байна.

Их Британийн эдийн засаг 2-р улиралдаа 20.4%-аар агшсанаар албан ёсоор эдийн засгийн уналтад орсноо зарлажээ. Хэрэглээ, засгийн газрын зардал, экспорт, импорт, болон бизнесийн хөрөнгө оруулалт маш их хэмжээгээр буурсан байна. Гэхдээ, 6-р сард эдийн засгийн сэргэлтийн шинж тэмдгүүд ажиглагдсан бөгөөд, ДНБ 5-р сарынхаас 8.7% өссөн байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоног дахин өслөө. Амралтын өдөр таарсан энэ долоо хоногт (Даваа гарагт Японы Уулын баярын өдөр тохиолдсон) Nikkei 225 индекс 959 пункт буюу 4.3% өсөж 23,289.36 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 1.6% бага байгаа юм. TOPIX индексүүд мөн өсөлттэй байсан ба Баасан гарагт 1 ам.доллар 107 иентэй тэнцэж байв.

БНХАУ: 8-р сарын 15-нд болох АНУ болон БНХАУ-ын худалдааны хэлэлцээртэй холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өөрчлөлт багатай байлаа. Өнгөрсөн зургаан сарын хугацаанд үргэлжилсэн худалдааны зөвшилцлийн биелэлтийг үнэлж дүгнэх тус уулзалтыг ихэнх шинжээчид зах зээлд эрсдэл учруулж болзошгүй гэж үзэж байгаа ч ерөнхийлөгч Доналд Трампын хувьд 11-р сард болох ерөнхийлөгчийн сонгууль хүртэл тохиролцоогоо хадгалж үлдэх сонирхолтой байгаа юм байна. Гэхдээ, БНХАУ нь АНУ-д амласан импортын хэмжээндээ хүрэхэд маш хол байсаар байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,446.15	0.26% ▲
Dow Jones	АНУ	27,931.02	1.81% ▲
S&P 500	АНУ	3,372.85	0.64% ▲
Nasdaq	АНУ	11,019.30	0.08% ▲
S&P/TSX	Канад	16,514.61	-0.18% ▼
FTSE 100	Их Британи	6,090.04	0.96% ▲
S&P/ASX 200	Австрали	6,126.20	2.02% ▲
Nikkei 225	Япон	23,289.36	4.30% ▲
Hang Seng	Хонг Конг	25,183.01	2.66% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.10
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.31
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.93
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.55
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.63
DBM' 2023	USD	7.250%	104.13
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	96.85

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.152	-0.07 ▼
Libor 3M	0.270	0.07 ▲
Libor 6M	0.333	0.08 ▲
Libor 1YR	0.461	0.03 ▲
US 2YR Bond	0.145	0.12 ▲
US 3YR Bond	0.180	0.28 ▲
US 5YR Bond	0.293	0.27 ▲
US 10YR Bond	0.703	0.25 ▲

Валютын ханш	2020.08.14	Өөрчлөлт
USD	2,847.99	0.06% ▲
CNY	409.91	0.25% ▲
EUR	3,361.20	-0.27% ▼
RUB	38.86	0.36% ▲
KRW	2.4	0.00%
JPY	26.68	-1.04% ▼
CAD	2,151.54	0.84% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,945.12	-4.44% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	26.45	-6.55% ▼
Зэс	USD/lb.	288.20	3.21% ▲
Нүүрс	USD/MT	53.78	-4.43% ▼
WTI газрын тос	USD/bbl.	42.01	1.92% ▲
Brent газрын тос	USD/bbl.	44.80	0.90% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.36	5.36% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VI	2.80%
Бодлогын хүү	2020.VI	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VI	8.95%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	10.98%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VI	4.33%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	17.03%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VI	10.43%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 55 компанийн 3,045.4 сая төгрөгийн 6,654,778 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Тээвэр дархан” /MSE: TEE/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 7,475.00 төгрөг хүрч хаагдсан бол “Нийслэл өргөө” /MSE: NUR/ компанийн хувьцаа 18.91%-аар буурч 3,000.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 7.7 сая төгрөгийн 77 ширхэг үнэт цаас арилжаалагдав


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

8-р сарын 14-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,531.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,446.15 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.26% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	3,053.1
Зах зээлийн үнэлгээ	2,531,331.9

Зах зээлийн индексүүд

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,446.15	0.26% ▲
MSE I индекс	8,115.64	0.57% ▲
MSE II индекс	7,409.00	0.00% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	3,597,828	2,459,637,081
Женко тур брью	1,103,765	341,610,647
Эрдэнэ ресурс девелопмент корп	58,916	54,229,710
АПУ	68,654	37,385,367
Бодь даатгал	257,199	30,568,924

Өсөлттэй хувьцаа

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Тээвэр дархан	7,475.00	15.00% ▲
Хай би ойл	64.00	14.28% ▲
Могойн гол	7,990.00	14.14% ▲
Стандарт агрикалчер групп	68.00	13.33% ▲
Багануур	950.00	11.47% ▲

Бууралттай хувьцаа

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Нийслэл өргөө	3,000.00	-18.91% ▼
Дархан зочид буудал	127.50	15.00% ▼
Булган гурил тэжээл	510.00	-13.55% ▼
Э-транс ложистикс	125.00	-11.47% ▼
Цагаантолгой	1,025.00	-10.86% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Инвекор Капитал	4,903,457,925
БиДиСек	825,625,271
Гаули	40,977,299
Стандарт Инвестмент	38,678,671
Ти Ди Би Капитал	38,259,641

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	549.00	584,235.67
Таван толгой	5,595.00	294,661.79
МИК холдинг	12,990.00	269,014.07
Инвекор ББСБ	2,650.00	190,078.98
Говь	194.22	151,513.45

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	77	7,700,000	100,000	100,000	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 8-р сарын 12-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаад улсын болон Монгол Улсын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй үнэт цаасыг бирж хооронд хөрвүүлэн арилжих боломж бүрдэж байгаа бөгөөд тухайн үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, хөрөнгө оруулагчид аль өндөр ханштай зах зээлийг сонгон арилжих боломж бүрдэх, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрөнгийн зах зээлд үнэт цаасыг хил дамжуулж хөрвүүлэх цоо шинэ харилцааг бий болгох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE: ERDN, TSX: ERD/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE: ERDN, TSX: ERD/ ХК нь Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг нэмэгдүүлэх, саяхан танилцуулсан нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнгүүдийг үргэлжлүүлэн Баян Хөндийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэхэд зарцуулахаар хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулалт бүхий 20 сая кан. долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

2020 оны 7-р сарын 23-ны өдөр танилцуулсан хаалттай хөрөнгө оруулалтын хүрээнд тус бүрийг 0.45 кан.доллараар үнэлсэн 33,333,333 нэгж захиалгын баримтыг Канад улсын томоохон хөрөнгө оруулагч ноён Эрик Спроттын эзэмшдэг 2176423 Ontario Ltd хуулийн этгээд худалдан авч, түүнтэй зэрэгцэн тус бүрийг 0.45 кан.доллараар үнэлсэн 11,111,108 ширхэг үнэт цаасны нэгжийг амжилттай арилжаалж хөрөнгө оруулалтыг хаасан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Женко тур бюро” /MSE: JTB/ ХК-ийн нийт хувьцааны 4.5% багцын арилжаагаар арилжаалагдлаа.

МХБ-ийн хувьцааны II ангилалд бүртгэлтэй “Женко тур бюро” /MSE:JTB/ ХК-ийн хувьцааг 8-р сарын 12-ны өдөр багцаар арилжаалсан байна.

Тодруулбал, тус компанийн 3,571,596 ширхэг хувьцаа нэг бүр нь 95.00 төгрөгийн ханшаар буюу нийт 339.3 сая төгрөгөөр арилжаалсан байна.

2020 оны 8-р сарын 7-ны өдрийн байдлаар компанийн 70.05%-ийг 5 том хувьцаа эзэмшигчид эзэмшиж байсан бол үлдсэн 29.95% нь 50,000 гаруй жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байжээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Говь” /MSE: GOV/ ХК 2019 оны компанийн засаглалын тайлан ирүүлээ

“Говь” /MSE: GOV/ ХК нь компанийн сайн засаглалыг хэрэгжилтийн сайжруулах зорилгоор компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайланг 3 дахь жилдээ гарган ирүүлсэн байна.

Тус компани нь өнгөрсөн онуудад засаглалын өөрийн үнэлгээг гаргахдаа бичиг баримтын боловсруулалтад илүү ач холбогдол өгч дүгнэсэн бол энэ жил бичиг баримтын хэрэгжилтэд анхаарч дүгнэсэн байна. Цаашид сайн засаглалаараа манлайлах зорилтыг тавин үйл ажиллагаанд мөрдлөг болгох баримт бичгийн боловсруулалтыг сайжруулж, түүний хэрэгжилт дээр илүү анхаарч тасралтгүй сайжруулалт хийж ажиллахаар болсон байна.

Манай улсын компани бүр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангахад чухал хувь нэмэр оруулах билээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Инвескор ББСБ” /MSE: INV/ ХК-ийн нийт хувьцааны 1.53% багцын арилжаагаар арилжаалагдлаа.

МХБ-ийн хувьцааны II ангилалд бүртгэлтэй “Инвескор ББСБ” /MSE: INV/ ХК-ийн хувьцааг 8-р сарын 10-ны өдөр багцаар арилжаалсан байна. Энэ нь 2020 он гарснаас хойш 4 дэх удаагийн багцын арилжаа болсон бол 8-р сар гарснаас хойш 2 дахь удаагийнх болж байна.

Энэ удаагийн арилжаагаар компанийн 1.1 сая ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 1.53%-ийг 2.45 тэрбум төгрөгөөр буюу нэгж хувьцааг 2,227.00 төгрөгөөр арилжаалжээ.


Эх сурвалж: MarketInfo.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ


ОНЦЛОХ МЭДЭЭ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 7-р сарын эцэст 21.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөгөөр буюу 5.3%-аар өсөхөд валютын хадгаламж 1.7 их наяд төгрөгөөр буюу 56.7%-аар, төгрөгийн хадгаламж 243.2 тэрбум төгрөгөөр буюу 2.2%-аар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 16.5 тэрбум төгрөгөөр буюу 2.6%-аар өссөн нь нөлөөлжээ.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



МАКРО ЭДИЙН ЗАСАГ



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 4.9 их наяд төгрөг байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь нийт орлогын 93.1 хувийг эзэлж байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 7-р сард 902.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 108.1 (13.6%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 308.5 (22.4%) тэрбум төгрөгөөр буурчээ. Харин улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 257.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 351.6 (56.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 7 сард урьдчилсан гүйцэтгэлээр 8.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (19.3%) их наяд төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.9 (26.4%) их наяд төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 14.0 (2.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 7 сард урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (26.4%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 1.8 (56.7%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолт 444.1 (74.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 7-р сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 5.9 (0.4%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 7.7 (0.8%) тэрбум төгрөгөөр, цахилгаан хий, уур, агааржуулалтын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 3.6 (4.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МХБ-ЫН I, II АНГИЛАЛД БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЦЭВЭР АШИГ


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

НИЙТ ХӨРӨНГӨ


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЭЗДИЙН ӨМЧ

тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ын I, II ангилалд бүртгэлтэй 60 хувьцаат компаниас 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа МХБ-ын цахим хуудсанд байршуулсан 51 компанийн санхүүгийн үзүүлэлтийг дээрх зургаар үзүүлээ.

2020 оны эхний хагас жилд тус компаниуд нийт 919.67 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4%-аар бага байгаа бөгөөд нийт цэвэр ашиг 30.30 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 58.0%-аар буурсан үзүүлэлт болсон байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг харвал тус компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 6,808.58 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6.2%-аар өссөн үзүүлэлт болсон бол нийт эздийн өмчийн хэмжээ 1,506.18 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 7.7%-аар өссөн байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.